



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/425

Номгон


Г
Заг, Баянцагаан сумын цагдаагийн бичил
байрны засварын ажилд хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Цагдаагийн албаны тухай хуулийн 94.1, аймгийн 2021 оны хөгжүүлэх төлөвлөгөөний 115 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагдаагийн албан хаагчдын ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор Заг, Баянцагаан сумын цагдаагийн бичил байрны засварын зардалд шаардагдах 3.212.000 (гурван сая хоёр зуун арван хоёр мянга) төгрөгийг 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

2.Дээрх сумдын бичил байрны засварын ажлыг 7 дугаар сард багтаан чанартай хийж гүйцэтгэхийг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Б.Оюутболд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДААГА  Д.МӨНХСАЙХАН

601210003